

**Human security and Sustainable development of education**

Khongorzul Tsetseg-Ulzii, Dolgormaa Dagdanbazar, Amarjargal Nergui

Article information**Article history:**

Received: 2024.11.05

Revised: 2024.11.13

Accepted: 2024. 11.19

Keywords:Human security
Sustainable development
of education**ABSTRACT**

Human security is a global issue. For example, the Covid-19 pandemic, the war in Ukraine, the Palestinian-Israeli gas pipeline conflict, climate change, the constant development of artificial intelligence, the P-Diddy sexual harassment and abuse scandals, etc. it has become a global citizenship or peacemaking, human security, and human rights issue rather than a national, inter-state, or regional issue. It is globally recognized that the role of education in achieving sustainable Development Goals is important and that education has a comprehensive impact on learning and development, innovation, critical and creative thinking, interdisciplinary learning, and life skills.

Our country focuses on educational institutions, curriculum, environment, training, scientific research, and innovation in strategic industries, and through research and analysis on multifaceted issues such as economic growth, enhanced competitiveness, support technological development, protect labor market, productivity, reduction poverty and reduce negative social phenomena, the future graduate will attention is paid to preparing “World citizen with a Mongolian appearance” with skills to overcome global challenges and competition. Finally, sustainable development of education is essential for human security.

Corresponding author:Khongorzul Tsetseg-Ulzii
Mongolian National Defence University
Email: note4ulzii@gmail.com**Хүний аюулгүй байдал ба Боловсролын тогтвортой хөгжил**

Цэцэг-Өлзийн Хонгорзул, Дагданбазарын Долгормаа, Нэргүйн Амаржаргал

Санал болгож буй эшлэл:

Хонгорзул, Ц., Долгормаа, Д., Амаржаргал, Н. (2024). Хүний аюулгүй байдал ба боловсролын тогтвортой хөгжил. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, Тусгай дугаар*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.11>

To cite this article:

Khongorzul, Ts., Dolgormaa, D., Amarjargal, N. (2024). Human security and Sustainable development of education. *Mongolian Journal of Educational Research, Special Issue*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.11>

ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА БОЛОВСРОЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

ОРШИЛ

Ирээдүйн залуусын боловсрол эмзэг байгаа тухай цөөнгүй судлаачдын судалгааны үр дүнгээс харж болно. Цар тахлаас үүдэлтэй танхимын сургалтын хоцрогдол, энх тайван бус байгаа бүс нутгийн залуусын боловсрол, хиймэл оюун, технологийн хурдацтай өөрчлөлтөөс үүдэлтэй ирээдүйд тааварлах боломжгүй шинэ ажлын байранд бэлтгэгдсэн хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай ур чадварыг одоогийн залуус эзэмшиж буй эсэх гэх мэт асуудлуудыг дурдаж болох юм. Эдгээр нь мэдээж тухайн улсын төдийгүй дэлхийн энх тайван байдал, тогтвортой хөгжил, эдийн засагт шууд нөлөө үзүүлнэ.

Дэлхийд өрсөлдөхүйц монгол төрхтэй, оюунлаг иргэд бэлтгэхийн тулд төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)-д “Боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан технологийн хөгжлийн түлхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа хэмээн үзэж, Монгол улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэж тодорхойлж байсан бол одоо “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “...эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болон хөгжинө” гэсэн эрхэм зорилгын хүрээнд “Хүний хөгжил” бүлэгтээ дэвшүүлсэн зорилтуудын дэд бүтцүүд нь боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, шинжлэх ухаан, инновац, хүнд ээлтэй амьдрах орчин, хөдөлмөрийн зах зээл, Монгол хүний удмын сангийн тухай авч хэрэгжүүлэхээр тусгаж өгчээ.

Тус хөгжлийн бодлогод уялдан 2020 онд Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030), 2023 онд Боловсролын багц хуулийг баталсан. Багц хуулийн шинэчлэлд Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулиуд хамаарна.

2024 онд БШУЯ болон БСҮХ нь “Монголын боловсролын хувирган өөрчлөлт” үндэсний чуулганыг зохион байгуулав. Тус чуулганд 21 аймаг, 9 дүүргийн төрийн байгууллагын төлөөлөл 16, Сурагчдын төлөөлөл 34, Залуучуудын төлөөлөл 89, Сургалтын байгууллагын төлөөлөл 206, Аймаг, нийслэлийн БШУГ-ын төлөөлөл 90, Мэргэжлийн байгууллагын төлөөлөл 86, Эцэг эхийн төлөөлөл 22, Малчин иргэдийн төлөөлөл 8, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 25, Нам, эвслийн төлөөлөл 10, Бизнес эрхлэгчдийн төлөөлөл 14 буюу нийт 600 хүн оролцсон (М.Итгэл & бусад, 2024)-ны үр дүнд: Монголын боловсролын алсын хараа, үнэт зүйл, суралцагчийн дүр төрх, тэргүүлэх чиглэлийн тодорхойлолтоос хэсэгчлэн авч үзвэл алсын хараа нь хувь хүний хөгжлийг дэмжих, үүний тулд суралцахуйгаар дамжин хувь хүн бүр бие даан насан туршдаа суралцдаг “Тасралтгүй суралцагч” байх Монгол суралцагчийн дүр төрхийг тодотгосон.

“Хүн ард нь оюун ухааныхаа хүчээр нийгмийн баялгийг хэрхэн бүтээж, ашиглаж, байгааг өнөөдөр аливаа улс орны хөгжил, дэвшлийн илэрхийлэл хэмээн үзэж, шинжлэх ухаан технологийн чадамжаар нь тухайн орны хөгжлийн түвшнийг хэмждэг.” (Б.Өлзийхуяг, 2010), мөн “Хүнээ хөгжүүлбэ. Хүнийхээ хүчээр хөгжбэ. Хүнийхээ төлөө хөгжбэ” (Боловсролын шинжлэх ухааны академи, 2002, 2021, х.1,170) гэх зэргээр хүнээ хөгжүүлэх, хувь хүний тасралтгүй хөгжих, насан туршдаа суралцахын утга учир, үзэл санаа олон судлаачдын бүтээлээс харж болно.

Тэгвэл хүний хөгжлийг тодорхойлогч үзүүлэлтийн тухайд товч дурдвал:

Хүний хөгжлийн индекс (ХХИ)-ийг бид жил тутамд судлан боловсруулж олон улсад мэдээлснээрээ тус үзүүлэлт судалгааны эх сурвалж болдог. ХХИ (хүний чадавхын хөгжлийг тодорхойлно)-ийг үндсэн гурван хэмжигдэхүүнээр илэрхийлж дараах аргачлалаар тооцно. Үүнд: ДН - Дундаж наслалтын индекс, БИ - Боловсролын индекс, ОИ - Орлогын индекс гэж ойлгоно.

ХХИ-ийг тодорхойлогч хүчин зүйлс болох дундаж наслалт, боловсрол, орлогын индексийг үнэлэхдээ хүний хөгжлийн хэмжүүрийг шууд (*хүний өөрийнх нь чадварыг нэмэгдүүлэх замаар хүний суурь хэрэгцээг хангах*) ба шууд бус (*хүний хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэх буюу сонголт хийх эрхийг олгох замаар хөгжүүлэх*) хэмжүүр гэж ангилж болох юм (Ц.Хонгорзул & Д.Долгормаа, 2024).

Манай улсын хувьд албан ба албан бус боловсролын тогтолцоотой учир нийт хүн ам бичиг үсэг тайлагдалт

дэлхийн бусад улсуудтай харьцуулбал хангалттай үзүүлэлт байдаг нь БИ-д голлох нөлөөлөл болдог. Гэсэн хэдий ч нарийвчлан шалгах бусад шалгуурууд (PISA гэх мэт)-аар хангалттай бус үнэлгээ авдаг нь нууц биш.

Боловсролын тогтвортой хөгжил нь тухайн улсын хөгжлийн үндэс юм. Улсын хөгжил нь хүний аюулгүй байдлыг хангах, хүнийг өөрийнх оролцоотойгоор болон орчны нөлөөгөөр хөгжүүлэх, насан туршдаа тасралтгүй суралцах-хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэхдээ бүх шатны боловсролын байгууллагаар дамжин явагддаг. Иймд боловсролын байгууллагын хүртээмж, оролцоо, боловсролын чанарын асуудлыг онцгойлон авч үзэж тогтвортой байдалд анхаарал хандуулах хэрэгтэй.

“Аюул” - ямар нэгэн тогтолцооны хэв шинж, мөн чанарыг алдагдуулах, тогтворгүй байдалд аваачихад чиглэсэн хүч (хүчин зүйл) илтээр оршин тогтнож, үйл ажиллагаа явуулж байгаа үйлдэл юм. (Ч.Улаанхүү 2014)

Аюулгүй байдал гэдэг нь аюулаас ангид байх, хадгалах чанар, найдвартай байдал (В.И.Даль), Хүн буюу ямар нэгэн юманд аюул учрахгүй байх (С.И.Ожегов), аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй (Я.Цэвэлийн тайлбар толь), хүн ба эд хөрөнгийг янз бүрийн аюулаас хамгаалах арга хэрэгслийн систем (Британика нэвтэрхий толь), хуримтлуулсан үнэт зүйлст аюул учрахгүй байх (Арнольд Вольферс) гэх мэт тодорхойлолт, үзэл санаа олон бий.

Аюулгүй байдал гэх ойлголт нь хувь хүнээс эхлээд дэлхий нийтийг хамарсан өргөн цар хүрээтэй ойлголт юм. Өмнө нь аюулгүй байдал гэх бие даасан ойлголт байгаагүй хэдий ч Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар олон улсын харилцаанд суурь шинэчлэлүүд хийгдсэнээр аюулгүй байдал гэх ойлголт улам идэвхтэй ашиглагдаж, улмаар аюулгүй байдал нь судалгааны бие даасан салбар болон хөгжиж байна. Аюулгүй байдал нь шинжлэх ухааны олон салбараас хамааралтай дэлхий нийтийг хамарсан өргөн цар хүрээтэй ойлголт юм. Тухайлбал олон улсын харилцаанд эдийн засгийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хүн төрөлхтний оршин тогтнохуйн аюулгүй байдал гэх мэт олон салбарт хамааруулан судалдаг.

Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 11 дүгээр зүйлийн 11.1 д зааснаар “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг”, мөн тус хуулийн 25.72-д “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэх” тухай зэрэг заалтаас үндэслэн Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (2001)-д “Үндэсний аюулгүй байдал”-ыг “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ” гэж, Үндэсний язгуур ашиг сонирхол гэдгийг “Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана” хэмээн тус тус тодорхойлсон.

Өөрөөр хэлбэл аюулгүй байдлын бодлого нь Монгол Улсын “оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал”, “хүний аюулгүй байдал”, “хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал” гэсэн цогц байдлаар үндэсний аюулгүй байдал баталгаажих тухай хуульчилсан. Үүнд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал” асуудлыг боловсруулан нэмэлт өөрчлөлт хийгдсэн.

Хүний аюулгүй байдлыг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.4-д “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж тодорхойлсноос гадна хүний хөгжил, боловсролын салбарт агуулгын хувьд тусгасан зарим заалтуудыг дурдвал:

3.1.3.1. Монгол Улсын хүн амын өсөлтийг дэмжиж, монгол хүний хөгжил, амьдралын чанарт дэвшил гаргана.

3.2.1.3. Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий

болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна.

3.2.1.6. Боловсролын салбарт олон улсын стандартыг мөрдүүлж, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, хүний хөгжлийг дээшлүүлэхэд чиглүүлнэ.

Онолын болон судлаачдын статистик, тоо баримт, эрх зүйн орчинд тулгуурлан нэгтгэн харвал тухайн улс аюулгүй байдлаа хангах, тогтвортой хөгжих суурь ойлголт нь эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хөгжлийн түлхүүр хүний аюулгүй байдал, хүний хөгжлийн асуудал төдийгүй эдгээр асуудлыг хуульд тусгахдаа хүн төвтэй байхаар хуульчилж өгсөн байна. Иймээс хүний аюулгүй байдлыг хангахад боловсролын байгууллагаар дамжуулан хүн насан туршдаа, тогтвортой хөгжил чухал оролцоотой болохыг ч харж болохоор байна.

ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Хүний нийгэм хувьсан өөрчлөгдөж, хүн хөгжих явцдаа учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлаа хангах, хор хөнөөлийн хэм хэмжээг бууруулахыг зорьдог хэдий ч хөгжихийн хэрээр сөрөг хүчин зүйлс нэмэгдэж, түүнийг дагаад хүний аюулгүй байдлыг хангах арга хэрэгсэл, механизм хувьсан өөрчлөгдсөөр ирсэн.

Монголын эртний төр ёсны сургаал, үе үеийн хаадын улс төр, цэрэг, дайны бодлого, дэлхийн томоохон дайнууд, зэвсэгт мөргөлдөөн, хилийн маргаан төдийгүй байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн хор хохирол, дотоодын дайсан гэх мэт хүний аюулгүй байдлыг хангах асуудлын түүхэн эх сурвалжуудаас харахад нэг талаас эхэн үедээ газар нутгийг эзлэн түрэмгийлэх, хүчирхэг байдлаа тогтвортой хадгалах, гадаад хамтын ажиллагаагаа бататгах, өргөжин тэлэх зэрэг асуудлууд, нөгөө талаас хүн хоорондын харилцааг зохицуулах дүрэм журам, шашны тэгш байдал, зан заншил, ёс уламжлалын шинжтэй холбоотой байжээ. Тухайлбал, эрх зүйн баримт бичгийн анхдагч болох Магна Харти (Magna Carta 1215) нь тухайн үеийн баронууд өөрсдийн эрхийг хамгаалахаар нэгдэж аргагүйн эрхэнд Ионн хаан буулт хийснээр одоогийн Английн нийгмийн харилцааг амжилттай зохицуулж ирсэн үндсэн хуулийн эх сурвалж, суурь нь болсон гэж үздэг. Учир нь тухайн эх сурвалжид нийгмийн янз бүрийн анги давхаргын ашиг сонирхол, Хаан болон түүний шүүх эрх мэдлийг хязгаарлах, улс төрийн шинэ тогтолцоог тогтоох зэрэг заалтууд байдаг нь үндсэн хуулийн шинжийг агуулсан байдаг. Өөрөөр хэлбэл төр, нийгэм, хувь хүн болон тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийн суурь тавигдсанаар хэн нэгэн бүрэн эрх мэдэлтэн (хааны нэрийн өмнөөс, эсвэл хаан өөрөө) өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн өндөр татвар авах, хэн нэгнийг боолчлох, албадан хөдөлмөрлүүлэх, өр төлбөр, зээл, баячуудын эрх мэдэл гэх мэт олон асуудал шийдвэрлэгдэж хүний эрх, хүний аюулгүй байдал хангагдах нөхцөл бүрдсэн юм.

Манай улсын хувьд 1924, 1940, 1960, 1992 онд Үндсэн хуулиа хэлэлцэн баталж одоогоор 1992 оны үндсэн хуулийг даган гарсан бусад хууль, үзэл баримтлал зэрэг бусад эрх зүйн баримт бичгүүдээр төр, нийгэм, хүн хоорондын харилцаа зохицуулагдаж байна. Хүний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж 1990-ээд оны эхээр ардчиллын нөлөөгөөр хүний эрх, үндсэн эрх чөлөөг үндсэн хуульдаа баталгаажуулж, түүнд холбогдох бусад эрхзүйн баримт бичгүүд гарсан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (ҮАБҮБ-2010 он)-д үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. оршин тогтнохуйн аюулгүй байдал
2. эдийн засгийн аюулгүй байдал
3. дотоод аюулгүй байдал
4. хүний аюулгүй байдал
5. хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал
6. мэдээллийн аюулгүй байдал, шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал.

Хүний аюулгүй байдал (ҮАБҮБ-ын 3.4-д. 2010 он) гэдэгт “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” хэмээгээд хүний аюулгүй байдлыг хангахдаа эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх,

хүнсний аюулгүй байдал, амьдрах орчны аюулгүй байдал, иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах арга замуудын тухай багцалсан байна.

Хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангах глобал асуудалд нэгдүгээрт, дэлхийд энх тайван байдлыг тогтоон хадгалах хоёрдугаарт, байгаль орчныг бохирдуулах, унаган төрхийг алдагдуулахтай холбоотой экологийн асуудал гуравдугаарт, хүн амын өсөлт болон хүмүүсийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хүн ам зүйн асуудал дөрөвдүгээрт, хүнсний асуудал тавдугаарт эдийн засгийн асуудал зургаадугаарт, дэлхий ертөнцийн эрсдэл, түүхий эд, бусад байгалийн баялгийн нөөцийн хязгаарлагдмал байдалтай уялдсан эрчим хүч түүхий эдийн асуудал долоодугаарт, мэдээллийн асуудал наймдугаарт, хүн төрөлхтний эрүүл мэндийн асуудал зэрэг хамрагдаж байна (Б.Өлзийхуяг & Т.Намсрай, 2022).

Тогтвортой байдал, тогтвортой хөгжлийн чиг хандлага нь аюулгүй байдалд хандах орчин цагийн чиг хандлагыг бүрдүүлснээр хөгжил ба аюулгүй байдал гэх ойлголтууд эсрэг тэсрэг бус харин ч хоорондоо нягт холбоотой болсон.

Өөрөөр хэлбэл хүн төрөлхтний аюулгүй байдлын асуудал нь сүүлийн жилүүдэд улс орон бүр өөр өөрийн хүчирхэг нийгмийг бүрдүүлэх тухай бус хамтдаа учирч болзошгүй аюулд бэлэн байхын тулд мэдлэг, мэдээлэлтэй ойр байж, зохистой ашиглах, энх тайвныг эрхэмлэх, технологийн үсрэнгүй хөгжилд хүмүүсийг бэлтгэх гэх мэт хүний аюулгүй байдал, хүний хөгжлийн асуудлууд дэлхий нийтийн нийтлэг тулгамдсан асуудал болоод байна.

1994 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хүний хөгжлийн тайланд хүний аюулгүй байдлыг аливаа гэнэтийн санамсаргүй түрэмгийллээс хамгаалах явдал хэмээгээд хүний аюулгүй байдалд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг авч үзсэн нь улс төр, эдийн засаг, хүнс, эрүүл мэнд, амьдрах орчин, нийгэм ба хувь хүний аюулгүй байдлыг нэрлэсэн байдаг. Түүнчлэн эдгээр хүчин зүйлс дээр боловсролын аюулгүй байдлыг нэмж болох юм.

ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА БОЛОВСРОЛ

Боловсрол бол хүний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг учраас аливаа улс орны хөгжил нь тухайн улсын хүний хөгжилтэй салшгүй холбоотой. АНУ, Хятад зэрэг их гүрнүүд болон хурдтай хөгжиж буй улсуудын өрсөлдөөний нэг талбар бол боловсролын салбар юм. Учир нь өнөөгийн хиймэл оюун ухааны хөгжүүлэлт, алсын удирдлагатай төхөөрөмжүүд, ухаалаг технологийн шийдлүүд, дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, байгалийн баялгийн оновчтой зохицуулалт, дэлхийн хамгийн хамгийн тодотголтой барилга байгууламж, хүрээлэн буй орчиндоо ээлтэй амьдрах хэв маяг, хүний эрүүл мэнд, хүнсний хомсдолын шийдлүүд гээд олон асуултын шийдлийг мэргэжлийн ур чадвартай хүний оюун ухааны санал санаачилгаар бий болгож байна.

Монгол Улсын хүний аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал боловсролын салбарын тогтворгүй байдал гэдэгт санал нэгдэх биз ээ. Иймд бид цаашид хүний аюулгүй байдлаа хангах, хүнээ хөгжүүлэхийн тулд боловсролын салбарын тулгамдсан асуудлуудад анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэн эрх зүйн орчны шинэчлэлийг (Боловсролын багц хууль) 2023 оноос хийж, хэрэгжүүлсээр байна.

Мөн салбарын экспертүүд нийгмийн бүлгүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг хийж, судалгаа явуулсны үр дүнд шинжлэх ухаанд суурилсан оновчтой хөгжлийн зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тасралтгүй ажилласаар байна. Үүнд:

- Монгол хүний онцлог, монгол суралцагчийн дүр төрх, хүмүүжил, соёл, зан заншил, эрхэмлэх үнэт зүйлтэй болгон төлөвшүүлэх;
- Гадаад улс орнуудын хөтөлбөрийг шууд дуурайлгах бус сайн туршлагыг өөрийн онцлогт тохируулан тогтвортой хэрэгжүүлэх;
- Бүх шатны боловсролын чанарыг сайжруулах;
- Олон улсын боловсролын хамтын ажиллагааг сайжруулах;
- Шинжлэх ухаан, технологи, инженер зэрэг урт хугацааны инновацын болон эдийн засгийн ашигтай салбаруудад хөрөнгө оруулалт хийх.

Аливаа улс орны хөгжлийн суурь нь “хүн” байдгийг ухаарч, хүний хөгжлийг боловсролын тогтвортой байдлыг хангах замаар сайжруулж чадвал хүний аюулгүй байдлыг хангах чухал ач холбогдолтой.

Тухайлбал, Хүн амын удмын сангийн аюулгүй байдалд үзүүлэх боловсролын нөлөөлөл:

1. Хүүхдийн хүмүүжил, төлөвшил;
2. Боловсролын эрх тэгш байдал;
3. Оюун санааны дархлаа (хараа хяналтгүй мэдээ, эх сурвалж нь тодорхойгүй мэдээллийн урсгал) (Ц.Хонгорзул & Д.Долгормаа, 2024);

Хүн амын насжилт хувь хүний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл, тэр дундаа боловсролын салбарт нөлөөлөх байдал:

1. Насан туршийн боловсролыг дэмжих тогтолцоо, хөтөлбөр;
2. Хөдөлмөрийн зах зээлд оролцох, шинэ мэргэжлээр давхар сургах, хөдөлмөр эрхлүүлэх;
3. Мэдлэг мэдээллийн системийн өөрчлөлтөд дасан зохиох, цахим орчноос мэдээлэл авах ур чадвар, боловсролыг нэмэгдүүлэх шаардлагатай (Д.Энхчимэг & М.Индрабүд, 2019).

БОЛОВСРОЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Боловсролын тухайд:

- Боловсрол нь хүн төрөлхтний олон мянган жилийн турш хуримтлуулсан бүх төрлийн шинжлэх ухааны мэдлэгийн өв сан; амьдралаас, туршлагаас, орчноос тухайн хүн эзэмшсэн мэдлэг, чадварын цогц юм (Л.Жамц);
- Боловсрол бол нэгдүгээрт: Хөгжлийн түлхүүр, хоёрдугаарт: Үндэсний аюулгүй байдлын үндэс юм (О.Үржин);
- Боловсрол: I.1.2 [ж.н] боловсрох үйлийн нэр (Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь);
- Боловсрол өөрөө цогц ойлголт юм. Хүн амьдралаа үр бүтээлтэй, аз жаргалтай, бусдад гай болохгүй өнгөрөөх цогц мэдлэг чадваруудыг л боловсрол гэж нэрлэнэ (Ж.Ариунболд);
- Боловсрол гэдэг бол амьтнаас хүнд шилжих процесс мөн (Ө.Ганзориг);
- Боловсрол хүний сэтгэлгээний цар хүрээг тодорхойлогч байж болох ч хүнд зөв хандлагыг төлөвшүүлдэг түлхүүр нь байх ёстой (Д.Долгормаа);
- Боловсрол гэдэг нь хүн төрөлхтний амьдрах ухаан, соёлыг үеэс үед өвлүүлэн дамжуулах хэрэгсэл юм (Б.Өлзийхуяг)
- Боловсролын зорилго залуучуудыг насан туршдаа боловсорч байхад бэлтгэх ёстой (Robert Maynard Hutchins).

Боловсролтой хүн гэж хэнийг хэлэх вэ? гэдэгт:

- Сэтгэлгээний соёлтой хүнийг боловсролтой хүн гэнэ. Хүн бүр сэтгэн боддог. Хүн бүр мэддэг, мэдсэнээ ухаарч ойлгодог, ухаарч ойлгоод дүгнэлт хийдэг. Гэвч ийм дүгнэлт хангалттай биш. Сэтгэн бодсон дүгнэлт л үнэнд ойр байна. Сэтгэн бодно гэдэг нь хэлтэй холбоотой. Эх хэлний боловсрол сэтгэн бодоход нөлөөлснөөр боловсролтой Монгол хүн бий болно. (Д.Бадарч);
- Зөв хандлагатай, Зүрх сэтгэлийн боловсролтой хүнийг л боловсролтой хүн гэнэ. (Б.Тэмүүлэн).

Энэ мэтээр боловсрол, боловсролтой хүн гэж хэнийг хэлэх тухай тогтсон, нэгдмэл тодорхойлолт байхгүй. Харин хөгжлийн тухай ойлголт, онол, үзэл баримтлал, судлаачдын байр суурь салбар бүрд өөр өөрийн онцлогтойгоор тодорхойлогдсон байдаг. Хүний хөгжлийн үүсэл түүхийг сөхвөл хүн үүссэн цаг үетэй хөл нийлүүлэх нь гарцаагүй.

Хүний хөгжлийн онол, үзэл баримтлалуудаас жишээ дурдвал:

Хүний хөгжлийн биогенетик онол: Америкийн нэрт эрдэмтэн Стэнли Грэнвилл Холл уг онолдоо хүний хөгжлийн үйл явц нь тодорхой үе шаг дамжин хэрэгжих эрэмбэлэгдсэн үйл явц бөгөөд генетик шинж чанартай болно хэмээсэн. Өөрөөр хэлбэл, хүн хөгжих явцдаа хүний биологийн хувьслын үе бүхнийг богино хугацааны давтамжтайгаар туулдаг гэж үзнэ.


Сэтгэцийн задлан шинжилгээний онол: Германы эрдэмтэн З.Фрейд уг онолыг анхлан хөгжүүлсэн. Хүний зан байдал, мэдлэг, туршлага, өөрөөр хэлбэл хөгжил ухамсарлагдаагүй үйлдлийн үр дүнд бий болдог. Ухамсарлагдаагүй үйлдлээ ухамсарлах гэж оролдох нь сэтгэцийн эмгэгт байдалд хүргэдэг байна. Гэхдээ хүний сэтгэц ухамсарлагдаагүй, ухамсарлагдахын өмнөх, ухамсарлагдсан гэсэн гурван бүтэцтэй. Ухамсарлагдаагүй үйлдлийг ухамсарлах гэж оролдох нь сэтгэцийн эмгэгт хүргэнэ. Харин ухамсарлагдахаас өмнөх үйлдлийг ухамсарлаж болно.

Э.Эриксоны онол: Аливаа хүн төрөхөөс үхэх хүртлээ тасралтгүй хөгжиж байдаг. Хүн амьдралын эрэмбэлэгдсэн үе шатаар дамжин хөгжинө. Эдгээр үе шат нь бүгдэд адил бөгөөд нийт найман үе шаттай. Хөгжлийн үе шат бүхэн хүнд янз бүрээр үйлчилж болно. Хүн нэг үе шатаас нөгөөд шилжихдээ хямралын байдалд ордог. Эмчлэх арга нь буцаах явдал юм. Хүний хөгжлийг хангах гол хүчин зүйл нь бусадтай харилцах явдал болно.

Ж.Уотсоны бихевиорист онол: Хүний хөгжил сэдэл-хариу үйлдэл гэсэн зарчмын дагуу явагдана. Хүний хөгжилд голлон нөлөөлөгч хүчин зүйл нь орчны нөлөө юм. Хайр, айдас, дарлал гэх гурван орчин байх бөгөөд хүний цаашдын хөгжил төлөвшин тогтоход тэргүүн зэргийн нөлөөтэй байдаг гэж сургадаг.

Өнөө үед хүн судлал, боловсрол судлалын шинжлэх ухааны эрдэмтэд хүний хөгжлийг бие физиологийн, танин мэдэхүйн, нийгэмшлийн гэсэн үндсэн гурван бүлэгт хувааж үзсэн байна (Бэгз нар, 2018, х.10). Оршин тогтнохын үндэс нь Монголын боловсролын философи, Чиглэх алтан гадас нь Алсын хараа, Алсын хараа руу хөтлөх луужин нь Үнэт зүйл, Нийгэмд төлөвших хүн нь Монгол суралцагч, Монгол суралцагчийг дэмжих Тэргүүлэх чиглэлүүд, Олон нийтийн оролцоог эрхэмлэсэн Хамтын ажиллагаа, түншлэл, Хэрэгжилтийг найдвартай, тогтвортой байлгах Боловсролын цахим шилжилт ба их өгөгдөл, Үр дүнд суурилсан Боловсролын санхүүжилт хэмжээн тодорхойлж байна. (М.Итгэл & бусад, 2024)

Улсынхаа оршин тогтнохуйн аюулгүй байдлыг хангахдаа хүний хөгжил буюу хүнийг үнэт зүйл хэмээн харж хүнд төвлөрөн хөгжсөн тод жишээ бол Сингапур улс юм. Сингапур улсын хөгжлийн тухай эх сурвалжуудад Ли Куан Ю хэмээх эрхмийн алсын хараа, хөгжлийн бодлого, асуудлыг даван туулсан арга замыг өгүүлэхдээ газар нутгийн хувьд баялаг бүтээх боломж хомс бараг л жижигхэн арлыг агуу улс болгон хөгжүүлээд зогсохгүй Зүүн өмнөд Азийн улс орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа, харилцаа холбоог бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болсон тухай өгүүлдэг. Хүн буюу хүний хөгжлийг боловсролын салбараар дамжуулан хөгжүүлж боловсрол болон бизнесийн салбарт хамтын ажиллагааг нээлттэй уян хатан зохицуулалт хийснээр Сингапур улсын хөгжил асар хурдтай өөрчлөгдсөн гэгддэг.



Зураг 1. Боловсролын ба хөгжлийн хамаарал
(Interrelation between Education and Development, 2023)

Боловсрол бол хөгжлийг хурдасгагч хөдөлгүүр юм. Тухайн улс тогтвортой эсвэл асар хурдтай хөгжих хүсэлтэй бол алсын хараа, үнэт зүйл нь хүн байж, хүнийг хэрхэн хөгжүүлэх бодлогоо оновчтой тодорхойлж, тогтвортой хэрэгжүүлэх явдал болно. Хөдөлгүүрийн хурдыг тодорхойлогч гол нөлөөлөл болох хувь хүн нийгмийн өөрчлөлтийг даган хувьсах, эсвэл өөрийн хүсэл тэмүүлэлтэйгээр өөрчлөгддөг. Өөрөөр хэлбэл төрийн бодлогоор, эсвэл өөрийн хүслээр буюу зохих эрхээ эдлэх замаар хүн хөгжиж болох юм.

ДҮГНЭЛТ

Тухайн улсын оршин тогтнохуйн үндэс нь хүний аюулгүй байдлыг хангах, хүнээ хөгжүүлэх замаар нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтвортой байдлаа ханган хамгаалах явдал юм. Хүнийг хөгжүүлэх гол түлхүүр нь боловсрол, боловсролтой Монгол төрхтэй хүн бүтээхийн тулд төрөөс боловсролын талаар баримтлах бодлого тогтвортой урт хугацааны, алсыг харсан байх хэрэгтэй.

Иймээс боловсролын тогтвортой хөгжил нь нийгмийн байдлыг даган хувьсдаг бус дэлхийн стандарт, хөгжлийн бодлого ба тухайн улсын зан заншил, ёс уламжлал, онцлогийг хамтад нь агуулсан өнгө төрхтэй байх нь зохистой бөгөөд хүнд суурилсан бодлоготой байх нь тодорхой болоод байна.

Боловсролын бодлого нь хүн төвтэй байж чадвал Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүн төвт үзэл санааны уялдаа холбоог бэхжүүлж өгөх юм.

НОМ ЗҮЙ

Итгэл, М., Отгонбаатар, Х., Санжаабадам, С., Туяа, У., Энхжаргал, Х., & Дэнсмаа, Ж. (2024). Монголын боловсролын тогтвортой хөгжүүлэх үзэл санаа. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл*, 29(2). <https://doi.org/10.56380/mjcr.v29.2.1>

Бэгз, Н. (2021). Тогтвортой хөгжил дэх хүний хөгжил, төлөвшлийн асуудлууд. *Боловсролын хүрээлэн-Эрдэм шинжилгээний бичиг*, 26. 6–19. Улаанбаатар.

Энхчимэг, Д. Индрабүд, М. (2019). Хүний аюулгүй байдалд насжилт нөлөөлөх нь. *Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл*, 28(38). Улаанбаатар.

Хонгорзул, Ц., Долгормаа, Д. (2023). Хүний хөгжлийг үнэлэхэд нөлөөлөх зарим хүчин зүйлсийн судалгаа. *Дээд боловсрол сэтгүүл*, 3(10). Улаанбаатар.

Бэгз, Н. (2008). *Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд*. Улаанбаатар: Соёмбо принтинг. Боловсролын хүрээлэн. (2018). *Боловсролын хөгжил: Судалгаа, арга зүй*. Улаанбаатар: Гоо дизайн.

Өлзийхуяг, Б. (2010). *Боловсрол судлал түүний үндсэн агуулга*.

Өлзийхуяг, Б., Намсрай, Т. (2022). *Шинжлэх ухааны танин мэдэхүйн арга судлал*.

Жахан, С., Долгоржав, Я., Сувд, Б. (2006). *Хүний хөгжил*.

Улаанхүү, Ч. (2014). *Аюулгүй байдлын онол, арга зүй*.

Улаанхүү, Ч. (2009). *Аюулгүй байдал*.

Irina Bokova. (2023). Education and human security. *Cadmus journal*, V5(12).

Хууль

Монгол улсын үндсэн хууль 1992. (Монгол Улс). Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

Монгол улсын аюулгүй байдлын тухай хууль 2001. (Монгол Улс). Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=18>

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010. (Монгол Улс). Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208070&showType=1>

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай. 1995. (Монгол Улс). Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=3782>

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он) 2015. (Монгол Улс). Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail/10935>

“Алсын хараа -2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого. 2020. (Монгол Улс). Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057>

Боловсролын ерөнхий хууль 2023. (Монгол Улс). Тагаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?law-Id=16759958962301>